



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2015.05.16 № 22

Асуулга тавих тухай

Улс орны хөгжил дэвшилд хүн амын боловсрол, эрүүл мэнд, амар тайван аюулгүй байдал чухал үүрэгтэй билээ. Монгол Улсын Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөрт "...иргэн бүр эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцөл бүрдүүлэхэд бүх талаар анхаарч..." гэж тусгасан бөгөөд энэ хүрээнд тэтгэвэр, тэтгэмж, цалинг үе шаттай нэмэгдүүлэхээр тусгасан.

Эрүүл мэнд, боловсролын салбар, цагдаагийн байгууллагын үйлчилгээг шинэ шатанд гаргахын тулд эмч, багш, цагдаа нарын цалин хөлсийг нэмэгдүүлэх, тэдгээрийн нийгмийн хамгааллын асуудлыг сайжруулах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Эрдэм боловсролтой, эрүүл монгол хүнийг бэлтгэх, хүн ардынхаа амар тайван аюулгүй байдлыг хамгаалахад нэгэн насны амьдралаа зориулан хоёргүй сэтгэлээр зүтгэж буй багш, эмч, цагдаа нараа дэмжих нь монгол төрийн үүрэг юм. Нөгөө талаар 2014 оноос хойш эмч, эмнэлгийн ажилтнуудын цалин нэг ч төгрөгөөр нэмэгдээгүй, багш, эмч, цагдаа нарын цалин хөлс өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтөд гүйцэгдэж, тэдний худалдан авах чадвар жилээс жилд муудаж, үүнээс улбаалан сүүлийн үед мэргэжлийн өндөр ур чадвартай олон боловсон хүчин гадаадад гарч хүний нутагт хүнд хөдөлмөр эрхлэх явдал нэмэгдэж байна.


Иймд монгол хүний эрдэм боловсролын хөтөч, эрүүл жаргалтай, амар амгалан амьдралын манаач болсон багш, эмч, цагдаа нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах үүднээс тэдний цалин хөлсийг нэмэгдүүлэх, ур чадвар, ачаалалд нь тохирсон урамшууллын шударга тогтолцоо бий болгох шаардлагатай хэмээн үзэж байгаа юм.

Иймээс Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасны дагуу УИХ-ын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараахь асуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд Танд хандан тавьж байна. Үүнд:

1. Өнөөдөр улсын хэмжээнд хэчнээн багш, нийгмийн ажилтан, эмч сувилагч ажиллаж байгаа, тэдгээрийн сард авч буй дундаж цалин хөлс яг ямар хэмжээнд буй талаар тодорхой тоон мэдээлэл ирүүлэх;
2. Хөдөө орон нутаг, тэр дундаа алслагдсан бүсэд ажиллаж буй эмч, багш, цагдаа нарт бүсийн нэмэгдэл, ур чадварт нь нийцсэн урамшуулал олгох чиглэлээр Засгийн газраас баримталж буй бодлого;
3. Салбарын яамд болон Нийгмийн гурван талт түншлэлийн хүрээнд багш эмч нарын цалин хөлсийг нэмэгдүүлэх талаар ямар тооцоо судалгаа хийсэн, цагдаагийн алба хаагчдын хүн хүч жишиг норматив хэмжээнд хүрэхгүй байгаагаас үүдэлтэй үүссэн ачааллыг хэрхэн бууруулах, хэдийнээс цалин хөлсийг нэмэгдүүлэх бодит боломж буй талаар;
4. 2017 оны төсөвт суусан багш нарын үр дүнгийн урамшуулал 45 хувиар олгогдох ёстой байсан ч ямар учраас 23 хувиар өгсөн талаар, цаашид урамшуулал олгох асуудлыг хэрхэн шударга хуваарилах, багш, эмч, цагдаа нарын хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэх, бодитой болгох, тэдний нийгмийн хамгаалал, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх талаар ойрын хугацаанд хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын талаар;
5. Цагдаагийн алба хаагчдын цалинг бодохдоо ажилласан хоногт нь нийтээр амрах баярын өдрүүдийг оруулан тооцохгүй байгаа алдааг засах, энэ тухай Хөдөлмөрийн хуульд заасан зоицуулалтыг бүрэн хэрэгжүүлэх чиглэлээр хийж буй ажлын талаар тодорхой хариултыг боловсруулж ирүүлнэ үү.

Энэхүү асуулгын хариуг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



С.БЯМБАЦОГТ
Ж.БАТЗАНДАН